| | | |
|---|---|---|
| 2006 оны 3 дугаар<br>сарын 22-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар<br>хот |

Засгийн газрын үйл ажиллагааны
тэргүүлэх чиглэл батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангахтай холбогдсон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохион байгуулж төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллага, төрийн бус болон хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага, иргэдийг татан оролцуулах чиглэлээр ажиллахыг сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХБОЛД

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга С.БАТБОЛД

*Засгийн газрын 2006 оны 54 дүгээр тогтоолын хавсралт*

*ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ*

*1. Боловсролын хүртээмж, чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний хөгжлийн түвшинг ахиулах;*

*2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажиллагчид бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын дэвшилттэй арга, хэлбэрийг ашиглан ажиллагсдын зах зээлд өрсөлдөх ур чадвар, чадавхийг нэмэгдүүлэх;*

*3. Эдийн засгийн бодит өсөлтийг тогтворжуулж, түүний үр шимийг иргэн бүр хүртэхүйцээр нийгмийн баялгийн хуваарилалтыг оновчтой болгож, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх;*

*4. Хөдөлмөр эрхлэж орлогоо нэмэгдүүлэхэд нь бичил зээл, санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэх замаар ядуурлыг бууруулах;*

*5. Иргэдэд газар болон үл хөдлөх хөрөнгө өмчлөх тааламжтай орчин бий болгох, бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх;*

*6. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих дэд бүтэц, татвар, санхүүгийн тааламжтай орчин бий болгон ажлын байр нэмэгдүүлж ажилгүйдлийг багасгах;*

*7. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэх, усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж, "Мянганы зам"-ыг барих ажлыг үргэлжлүүлэх, эрчимжсэн хөдөө аж ахуйг түлхүү хөгжүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах;*

*8. Засаг захиргааны хуваарийг үе шаттайгаар боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах, "Цахим засаглал"-ыг хөгжүүлж, төрийн үйлчилгээний үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх замаар хүнд суртал, авилгалын илрэлтэй тэмцэх;*

*9. Байгаль хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, байгаль орчны доройтол, агаарын бохирдлыг багасгах;*

*10. Уул уурхай, эрдэс баялгийн салбарыг олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болгох, хөрөнгө оруулалтын харилцан ашигтай бодлогыг тууштай баримтлан, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах.*

*-----оОо-----*